



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 210.

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх  
тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Гүйцэтгэх захирлын 2016 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 58 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан "Фронтиер УЦК" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
- Цаашид хууль тогтоомж, журам заавар болон "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийтай байгуулсан "Гишүүнчлэлийн гэрээ"-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг "Фронтиер УЦК" ХХК /Macateru Игата/-д анхааруулсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.БОЛОР